

Сонгинохайрхан дүүрэг

Сонгинохайрхан дүүрэг Монгол Улсын Их хурлын 1992 оны 18 дугаар тогтоолын дагуу Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 100 төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр анхны хуралдаанаа 1992 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр хийсэн. Энэхүү анхны хурлаас Сонгинохайрхан дүүргийг 1992 оны 10 дугаар сарын 1-ний өдөр байгуулах тухай тогтоол гаргасан.

Октябрийн районоос эдүүгээгийн Баянгол дүүргээс өрх тусгаарлан шинэ дүүрэг өнө эрнтий түүхт ариун дагшин онгон шүтээнт Сонгинохайрханаа түшин өрхөө татаж гал голомтоо асаасан.

Сонгинохайрхан дүүрэг нь нийслэлийн баруун жигүүрт Баянгол дүүрэг болон Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдтай хил залган оршдог Засаг захиргааны нэгжийн хувьд 25 хороотой, 120,1 мянган га нутаг дэвсгэртэй. 2007 оны байдлаар 48020 өрхтэй өрхийн 211056 хүн байнга оршин суудаг, дүүргийн нийт газар нутгийн 77 хувийг аж ахуйн эдэлбэр газар 19,4 хувийг ойн сав бүхий газар тус тус эзэлдэг.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар М.Баасанжав Тэргүүлэгчдийн даргаар Д.Дамдинпүрэв, 1994-1996 онуудад ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар О.доржрэнчин, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Д.Дамдинпүрэв,

1996-2000 онуудад Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Н.Банзрагч нарийн бичгийн даргаар Ч.Сайханбилэг, 2000-2004 онуудад Дүүргийн ИТХ-ын 35 төлөөлөгчдийн бүгд МАХН-ын гишүүд байсан. Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар П.Ганбаатар, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар О.Тунгалаг хурлын ажлын албаны даргаар Д.Батхуяг 2000-2002 онуудад, Ж.Сандагсүрэн 2002-2004 онуудад ажиллаж байсан. 2004-2007 хүртэл ИТХ-ын даргаар Д.Баярсайхан Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Ж.Үхтар 2004-2006 онд, Д.Оюунчимэг 2007 оноос ажиллаж байжээ.